



АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2022 оны 11 сарын 03 өдөр

Дугаар 0/263

Улаанбаатар хот

Г.Эрдэнэбилэгийн хөдөлмөр эрхлэлтийн харилцааг цуцлах, ажлаас чөлөөлөх, тэтгэмж, олговор олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2, 20.1.4, 20.1.10, Хөдөлмөрийн тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.1.2 дахь заалт, 82 дугаар зүйлийн 82.1 дэх хэсэг, 82 дугаар зүйлийн 82.1.2 дахь заалт, 83 дугаар зүйлийн 83.3, 80 дугаар зүйлийн 80.5 дахь хэсэг, Компанийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.9.8 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрчим хүчний салбарт ажилласан жил, мэргэжлийн хувьд ажлын байрны тодорхойлолтын шаардлагыг хангаагүй тул харилцан тохиролцсоны дагуу Аж ахуй, хангамжийн хэлтсийн дарга Ганбаатарын Эрдэнэбилэгийн хөдөлмөр эрхлэлтийн харилцааг 2022 оны 11 дүгээр сарын 04-ний өдрөөр дуусгавар болгон цуцалж, ажлаас чөлөөлсүгэй.

2. Аж ахуй, хангамжийн хэлтсийн даргын ажил хүлээлцүүлэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:

Ажлын хэсгийн дарга:

Ө.Удвал

(Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга бөгөөд Ерөнхий нягтлан бодогч)

Гишүүд:

Э.Ариунболд

(Зуухан цехийн дарга)

Н.Нэргүй

(Үндсэн хөрөнгийн нягтлан бодогч)

Г.Баярчимэг

(Цахим худалдан авалт хариуцсан ажилтан)

3. Ажлыг 2022 оны 11 дүгээр сарын 04-ний дотор актаар хүлээлцүүлж, баримтыг Захиргаа удирдлагын хэлтэст хүргүүлэхийг ажлын хэсэг (Ө.Удвал)-т үүрэг болгосугай.

4. Г.Эрдэнэбилэгт 3 (гурав)-н сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн тэтгэмж олгох, ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгүүлэх шаардлагагүй гэж үзсэн тул 2022 оны 11 дүгээр сарын 04-ний өдрөөс мөн оны 12 дугаар сарын 04-ний өдрийг хүртэлх хугацаагаар

дундаж цалин хөлснөөс тооцон олговор олгохыг Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга бөгөөд Ерөнхий нягтлан бодогч (Ө.Удвал)-д зөвшөөрсүгэй.

5. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа удирдлагын хэлтэс (Б.Ган-Очир)-г даалгасугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



М.МӨНХӨӨ

дундаж цалин хөлснөөс тооцон олговор олгохыг Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга бөгөөд Ерөнхий нягтлан бодогч (Ө.Удвал)-д зөвшөөрсүгэй.

5. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа удирдлагын хэлтэс (Б.Ган-Очир)-г даалгасугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



М.МӨНХӨӨ